



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/51

Мандалговь

Залуучуудын хөгжлийн зөвлөлийн
цахим сургалт зохион байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20.1.3, Төсвийн тухай 16 дугаар зүйлийн 16.5.5. Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаал, газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/48 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал, санаачилгыг дэмжих болон тэдгээрийн эрхийг хангах зорилгоор “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн цахим сургалт зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн цахим сургалт зохион байгуулахад шаардагдах 248200 (Хоёр зуун дөчин найман мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичиг, ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

2021.06.02
1311501

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн
А/51 дугаар тушаалын дүгээр хавсралт



**ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ЦАХИМ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Төмөрбат

Залуучуудын хөгжлийн төвийн
ажлын албаны нарийн бичиг

Гишүүд


Т.Насандэлгэр

Залуучуудын хөгжлийн төвийн
Сургалт хариуцсан ажилтан

Ц.Идэр-Оргил

Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо,
хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн
11/01 дугаар тушаалын дүгээр хавсралт



**ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ЦАХИМ СУРГАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО**

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Зүүм /zoom/	эрх	500 оролцогч	248200	248200
Нийт					248200

~ ооо ~